

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас
Дундговь аймгийн засаг даргатай 2021
онд хамтран ажиллах гэрээний
гуравдугаар хавсралт

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДААС ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
2021 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2021.06.13

Д/д	Үндэслэж буй бодлогын баримт бичиг	Санхүү-жилтийн эх үүсвэр	Шалгур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хувь
Нэг. Хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэлийн чиглэлээр							
1.1	Бүх шатанд шийдвэр боловсруулах, батлах, хэрэгжүүлэхдээ иргэд, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн саналыг сонсох, тусгах, зөвлөлдөх, хяналт тавих нөхцлийг бүрдүүлж, оролцоог нэмэгдүүлэх.	-	Батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн хувь	2	2	Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг баримтлан аймгийн стратеги төлөвлөгөө, Хүний нөөцийн хөтөлбөр боловсруулахаар Dundgov.gov.mn цахим хаягаар иргэдээс 43 санал, хүсэлтийг хүлээн авч хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн A/01 дүгээр “Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог дэмжих тухай” захирамжаар аймаг, сумдын Засаг дарга нар аймаг, сумдын бүтээн байгуулалт, дэд бүтэц, байгаль орчин, нийгмийн салбарын хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Бямба гаригт иргэдтэй тусгайлан уулзаж тэдний санал, хүсэлтийг сонсох, шийдвэрлэх, идэвх санаачлагыг дэмжих, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж	70

						байна. Аймгийн ИТХ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.3.1.1-д заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого” боловсруулах ажлыг эхлүүлэн иргэд, олон нийт, төрийн албан хаагчдаас санал авч байна.	
1.2	Ач холбогдоо алдаж дагаж мөрдөхөө больсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгох, хуульд нийцүүлэх.	-	Холбогдох шийдвэрүү дийг хүчингүй болгох, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, үр дүнгийн тайлан	-	-	2021 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан шийдвэрүүдтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн хүчингүй болгох, хуульд нийцүүлэх талаар дүгнэлт ирүүлээгүй байна.	100
1.3	Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудаас хуулиар тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг гарган, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.	-	Судалгаа, шинжилгээг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээний талаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнасан байна.	2	2	Хүчин төгөлдөр мөрдөгдеж буй 192 хуулиар аймаг, сумдын Засаг даргад тусгайлан эрх олгосноос үндсэн чиг үүргийн 48, дэд чиг үүргийн 238 эрх олгогдсон судалгааг гаргав. “Сумдын удирдах ажилтан, албан хаагчийн зөвлөлдөх уулзалт, сургалт”-ын үеэр сумдын Засаг дарга нарт хуулиар тусгайлан олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг батлуулах шийдвэрүүдийн талаар сургалт, семинарыг зохион байгууллаа. 2021 оны эхний хагас жилийн байдлаар Луус, Өлзийт сумдын иргэдийн Төлөөлөгчдийн	100

						Хурлын батлан гаргасан "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" 2 эрх зүйн актыг улсын нэгдсэн санд бүртгүүллээ.	
--	--	--	--	--	--	--	--

100 хувь - 2, 70 хувь - 1

90

Хоёр. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр

2.1	Иргэдэд хүргэх эрх зүйн сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх чиглэлээр сумдын ЗДТГ-ын дарга, "Эрх зүйн хөтөч" нарыг чадавхжуулах сургалт, семинар зохион байгуулж, удирдлага, арга зүй, мэдээ мэдээллээр хангаж, хамтран ажиллах.	2.5 Орон нутгийн төсөв	Сургалт, семинар, мэдээ, мэдээллээр хангасан хувь	90	100	Эхний хагас жилд сумдын Засаг дарга, сумдын ЗДТГ-ын дарга буюу "Эрх зүйн хөтөч" орон тооны бус багийн ахлагч нарт "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллах, эрх зүйн албан бус цахим сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр сургалт, сурталчилгаа хүргэх, бэлтгэгдсэн эрх зүйн хөтөчүүдийг арга зүйн удирдлагаар хангаж, тэднийг дэмжиж хамтран ажиллах талаарх семинар, сургалтыг танхимаар зохион байгууллаа. Халдварт цар тахалтай холбогдуулан сумдын "Эрх зүйн хөтөч"-үүдийг чадавхжуулах эрх зүйн албан бус сургалтыг цахим хэлбэрээр аймгийн Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь реферэнт, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, аймгийн Насан туршийн боловсролын	100
-----	---	---------------------------	---	----	-----	---	-----

						төв зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран 60 эрх зүйн хөтөчүүдэд эрх зүйн сургалтыг амжилттай зохион байгуулж, тэдний асуусан асуулт бүрт хариулж, “Эрх зүйн хөтөч”-үүд бүрэн хамрагдаж цахим сургалтыг үр дүнтэй боллоо гэж үнэллээ.	
2.2	Улс оронд үүсээд байгаа нөхцөл байдалд нийцүүлэн бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн нэгдсэн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг хууль сахиулах байгууллагуудтай хамтран хөдөөгийн 3-аас доошгүй суманд зохион байгуулах.	3.0 Орон нутгийн төсвөөс	Тухайн жилд нэгдсэн сургалт, сурталчилг аа зохион байгуулсан сум, хамрагдсан иргэдийн тоо	2/200	3/412	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд халдварт цар тахалтай холбогдуулан сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр эхний хагас жилд эрх зүйн сургалтыг 5 удаа 162, сурталчилгааг 2 удаа 250 иргэд, албан хаагчдыг тус тус оролцуулан зохион байгуулж нийт 412 иргэд, албан хаагчдад эрх зүйн албан бус сургалт сурталчилгаа хийж, зөвлөгөө, лавлагаа, баримт бичиг боловсруулах чиглэлээр 105 иргэн, албан хаагчдад эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүллээ. Эрх зүйн албан ба албан бус сургалтыг сум, байгууллагуудын удирдлагууд, Эрх зүйн хөтөч нараар дамжуулан иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох 3 сарын аян зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх чиглэлээр бэлтгэгдсэн “Эрх зүйн хөтөч” нарыг чадавхжуулж, тэднээр дамжуулан сум бүрт хүрч, Эрх зүйн хөтөчийн нэгдсэн групп болон Дундговь Эрх зүйн хөтөч группүүдээр иргэн бүрт эрх зүйн боловсрол	100

						олгохоор зорьж ажилласан үр дүн гарлаа.	
2.3	Хүний эрхийг хамгаалах төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх.	-	-ХЭҮК, Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн ажиллах нөхцөл бүрдсэн байдал -Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлсэн үйлчилгээнд ий тоо	120	132	Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь реферэнттэй хамтран иргэдэд хүний эрхийн зөрчлийн талаарх зөвлөгөө, мэдээллийг биечлэн болон Хуульчийн “Про Бено өдөр-2021” арга хэмжээний хүрээнд 05 дугаар сарын 01-ний өдөр цахимаар иргэд, олон нийтэд хууль, зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулав. Тус оны эхний 5 сарын байдлаар иргэд, байгууллагаас ХЭҮК-д хандсан санал хүсэлт ирээгүй бөгөөд Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч эрүүгийн 25 хэргийн төлбөрийн чадваргүй 31 холбогдолчдод өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 132 иргэнд үзүүллээ. Аймаг, орон нутагт ажиллаж буй өмгөөлөгчид болон сумдад ажиллаж байгаа “Эрх зүйн хөтөч нарын дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэн сумдад нийт 300 ширхэгийг иргэдэд хургуулэхээр түгээлээ.	100
2.4	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотой төлөвлөж, хамтран хэрэгжүүлэх.	7.5 Орон нутгийн төсөв	Шударга байдлын үнэлгээ	69.8	70.5	Аймгийн ЗДТГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад иргэд, олон нийт, ИТХ-ын төлөөлөгчид, төрийн албан хаагчдаас санал авч Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн загварын дагуу 15 зорилго, 65 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, аймгийн Засаг даргаар 2021 оны 02 дугаар сард батлуулан хэрэгжилтийг 82.84 хувийн хэрэгжилттэй ханган ажиллалаа.	100

Аймгийн ИТХ-ын болон Засаг дарга нараас авлига, ашиг сонирхлын зэрчлээс ангид, авлига, хүнд сурталгүй “Дундговь авлигагүй хөгжинө” уриалтыг санаачлан хэрэгжүүлж, уг үйл ажиллагааг хэлтэс, агентлаг, сумд үргэлжлүүлэн иргэд, олон нийтийн оролцоотой зохион байгуулж байна.

-Аймгийн хэмжээний Нийтийн албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг шинэчлэн, 36 хэлтэс агентлаг, сумдын 379 хамаарлыг тогтоож, www.dundgovi.gov.mn сайтад ил тод сурталчилсан нь иргэдээс удирдлагуудын томилгоонд хяналт тавих нэхцлийг бүрдүүлсэн үйл ажиллагаа болов. Тус судалгааг аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт ил тод байршуулан, сум, байгууллагуудын удирдах албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдол бүрт шинэчилж байхыг салбар ЭБАТ-нуудад зөвлөн үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн ажиллаж байна.

-ХАСУМ хянуулсан дүгнэлт /албан бичиг/-ийг аймгийн www.dundgovi.gov.mn сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт, сум, байгууллагууд өөрсдийн цахим сайтад нийт ХАСУМ хянуулсан 50 дүгнэлтийг байршуулан ил тод нээлттэй сурталчилж шударга байдлыг ханган ажиллаж байна.

-Авлига, ашиг сонирхлын зэрчлээс урьдчилан сэргийлэх шторк, зурагт

						<u>хуудас, гарын авлагуудыг аймийн цахим сайт, сувгуудаар тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулж байна</u>	
100 хувь - 4							100
Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр							
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021 онд улсын болон орон нутгийн төсөвт 145.000.000 сая төгрөгийг баталсан.							
3.1	Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бодитой төлөвлөж, Гэмт хэрэг, зөрчлеөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах.	145.0 сая төг	Тухайн жилд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	211	206	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг тус зөвлөлийн нэгдүгээр хурлаар хэлэлцэн, 3 бүлэг 44 залттайгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээлэл, танилцуултыг аймийн Засаг дарга, ГХУСАЗСЗ-д танилцуулан гэмт хэрэг, зөрчлеөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021 онд улсын болон орон нутгийн төсөвт 145.000.000 сая төгрөгийг баталсан. Цагдаагийн газрын "Криминологи судалгааны баг" 3 удаа хуралдаж 2021 онд хийгдэх ажил, 2020 онд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээний хамт урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлын саналыг орон нутгийн удирдлагуудад хүргүүлсэн. Улсын хэмжээнд зохион явагдсан "ЭКО-2021", "Хайртай бүхнээ хамгаалъя", "Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна", "Мөрөөдлийн шүхэр", "Нөхөн сэргээлт-2021", "Нүүрс тээвэрлэлт", "Хүүхдэд ээлтэй жолооч" 7 удаагийн нэгдсэн арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулсан. Цагдаагийн газраас "Хорио цээр",	100

“Бүрэн бус тээврийн хэрэгсэл”, “Хулгайн тээвэр”, “Аз жаргалтай дурсамж”, “Хамтарсан багаараа хамгаалъя”, “Өсвөрийн сэргийлэгч”, “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдөр”, “Дотуур байр”, “Шаг”, “Эмзэг цэг” зэрэг 10 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээ тус тус зохион байгуулсан байна. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас улсын чанартай зам дагуух 3 суманд согтуурал хэмжихи багажаар хангасан. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажилд 450.000 төгрөгний үнэ бүхий микрофон олгосон. Зохион байгуулсан ажлын үр дунд 2021 оны эхний 5 сард аймгийн хэмжээнд 88 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17 хэргээр буюу 16.2 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

3.2	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд бүх шатны төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, сэтгэл зүйн тусламж, зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг нь тогтмолжуулах.	-	Хүүхдийн эсрэг үйлдэгдэг гэмт хэрэг болон хүүхдээс үйлдэгдэг гэмт хэргийн гаралт, Гэр бүлийн хүчирхийлл ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт	9	8	<p>“Би жөндерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна...” аяны хүрээнд байгууллагын цахим хуудсанд өөрсдийн бэлтгэсэн 8 төрлийн зурагт хуудас, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”-ээр 2 төрлийн видеог бэлтгэн байршуулж иргэд олон нийтэд хүргэсэн. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчтэй хамтран гэр бүлийн харилцааны зөрчилдөөнтэй 1 гэр бүлтэй ажиллаж, хууль, эрх зүй, сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлж байна. Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газартай хамтарч “Хамтарсан багаараа хамгаалья” аяныг зохион байгуулан аяны хүрээнд ахуйн хүрээнд архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэг, үйлдэж болзошгүй 15 айл өрхөөр орж урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, 3 төрлийн санамж сээрэмжлүүлэг түгээж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт хувийн хэрэг нээн хариуцсан багийн хэсгийн байцаагч нар биечилсэн хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын 2 сургуулийн дотуур байрууладад тухайн сургуулийн нийгмийн ажилтантай хамтран дотуур</p>	70

3.3	Архидан согтуурахтай тэмцэх орон	3.0	Согтуугаар	55	53	байрны орчинд эргүүл шалгалт хийж, өсвөр насын хүүхдийн үе тэнгийнхний дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх, "Хорт зуршил, архи тамхины хор хөнөөл" зэрэг сэдвээр яриа таниулгыг З удаа, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, "Үе тэнгийнхний дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх", "Архи тамхины хор нөлөө", "Цахим орчны зохистой хэрэглээ" зэрэг сэдвээр ерөнхий боловсролын сургуулийн 101 сурагчдад сургалт мэдээллийг тус тус зохион байгуулав. "Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдөр"-ийг тохиолдуулан Сайнцагаан сумын хамтарсан багтай хамтран иргэд олноор үйлчлүүлдэг зах худалдааны төв, гэр хорооллын усан сан /худаг/, түц зэрэг газруудад "Хүүхдийн эрхийн тухай ойлголт", "Хүүхэд хүмүүжлийн зэрэг аргууд" сэдвээр мэдээлэл хийж явуулын үйлчилгээ үзүүлж, эцэг эхчүүдэд зориулсан цуврал зөвлөмж 8-ыг боловсруулж, Цагдаагийн газрын болон 15 сумын зарын цахим хаягт байршуулсан. Хүүхдээс мэдүүлэг авах өрөөний зураг төслийг стандартын дагуу гаргаж аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хандан 9.024.700 төгрөг шийдвэрлүүлэн засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг эхлүүлээд байна.	Нийтээр тэмдэглэх баяр амралтын	70

	нүтгийн бодлого боловсруулан, хууль сахиулах болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв	үйлдэгдсэн гэмт хэргийн тоо			өдрүүд, шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хөл хороо тогтоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах аж ахуй нэгжүүдэд цагийн хязгаар тогтоох, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглох зохион байгуулалтын зарим арга хэмжээг авч, эхний хагас жилийн байдлаар нийт 29 захирамж гаргуулсан. Гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 17 иргэний зөрчлийг илрүүлж 85 шил архи, согтууруулах ундаа хурааж 850.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. Аймгийн ИТХ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.3.1.1-д заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого” боловсруулах ажлыг эхлүүлэн иргэд, олон нийт, төрийн албан хаагчдаас санал авч байна. 2021 оны 5 дугаар сарын байдлаар нийт 71 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 111 хүнээр буюу 60.9%-иар буурсан. Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 26.8 хувь нь гудамж, талбайгаас, 59.1 хувь нь гэр, орон сууцнаас, 5.6 хувь нь байгууллага, аж ахуй нэгжээс болон зочид буудлаас, 8.4 хувь нь бусад газраас эрүүлжүүлэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 27	
--	--	--------------------	-----------------------------	--	--	---	--

						бүртгэгдэж өмнөх оныхоос 2 хэргээр буюу 8 хувиар ёссэн байна.	
3.4	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах	3.0 Орон нутгийн төсөв	Мал хулгайлах гэмт хэргийн тоо	29	28	Мал хулгайлах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог дэшшүүлэх чиглэлээр “Дундговь аймгийн алдсан, олдсон малын зарын групп” шинээр үүсгэн 2000 дагагчидтай ажиллаж иргэдэд мал хулгайлах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, санамж, зөвлөгөө, анхааруулгыг хургэн ажиллаж байна. Мөн аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран 2021 оны 03 дугаар сард мал худалдан авдаг иргэд, аж ахуй нэгжүүдийг цуглуулж мал хулгайлах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, мал махны гарал үүслийн бичигт хяналт тавих журмын талаар сургалт зохион байгуулан ажилласан. Мал хулгайлах гэмт хэрэг эхний 5 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хэргээр буюу 12.5 хувиар ёссэн байна.	70
3.5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтад заасны дагуу харьяа нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодитой ажил, арга хэмжээ зохион байгуулах, шаардлагатай хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.	2.0 Орон нутгийн төсөв	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бууралт /тоо/	16	13	Зам тээврийн осол хэргийг бууруулах зорилгоор тус аймгийн Хулд сумын гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтарч 3 төрлийн шторк, 5 төрлийн зурагт хуудас хийж жолооч, иргэдэд мэдээллийн хэрэгслээр хүргэж ажилласан. Ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан улсын онцгой комиссын шийдвэрээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, Улаанбаатар хотоос шинжилгээнд хамрагдаагүй иргэд батлагдаагүй замаар зорчиж байгааг Автотээврийн төв, Цагдаагийн газрын НХКХТасагтай	70

3.6	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага, оролцоотой аймгийн төвийн томоохон гудамж талбайд хуучин камержуулалтыг шинэчилж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	30.0 Орон нутгийн төсөв	Зураг төсвийн гүйцэтгэл			хамтарч дээрх зам маршрут дээр хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан ба дээрх арга хэмжээнд нийт 1.183.840 төгрөгийг аймгийн онцгой комиссоос шийдвэрлэсэн. Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй “Хайртай бүхнээ хамгаалья” арга хэмжээний хүрээнд иргэд малчдын унаа болсон мотоциклын ослос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүмүүн бид нэг л амьтай” 8 минутын зохиомжийг бэлтгэн түгээж цахим хаягт байршуулж 1.005.470 иргэнд хүргэлзээ. Мөн орон нутгийн замд хурд хэтрүүлсний улмаас үйлдэгддэг ослыг бууруулах зорилгоор 2 төрлийн видео сээрэмжлүүлэг бэлтгэж цахим хуудсанд байршуулснаар 502 лайк, 158 түгээлт, 181.704 иргэнд хүргэсэн. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмээр 2 төрлийн зурагт худас хийж орон нутгийн олон дагагчтай зарын группд түгээсэн. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хэрээр буюу 20 хувиар ёссөн байна.		70

						үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хяналтын камер" хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Мэдээлэл холбооны сүлжээ зэрэг байгууллагуутдтай хамтран томоохон зах худалдааны төвүүдийн камерын системд үзлэг шалгалт хийж орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар албан мэдэгдэл өгсөн. Аймаг, сумын нийтийн эзэмшлийн талбайг камержуулах саналыг аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгуулсан. Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг эхний 4 сарын байдлаар 16 буюу 61.5 хувиар буурсан байна.	
100 хувь - 1, 70 хувь - 5							75

Дөрөв. Цагдаагийн байгууллагын чиглэлээр

4.1	Цагдаагийн газрын автомашинд засвар үйлчилгээ хийх болон сумдын хэсгийн цагдаагийн алба хаагчдыг унаажуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх.	Тухай бүр Орон нутгийн төсвөөс	Үзүүлсэн дэмжлэг туслалцаа	-	-	Аймгийн Засаг даргаас Цагдаагийн газрын үйл ажиллагааг дэмжин "Явуулын пост"-ыг 20.000.000 (хорин сая) төгрөгөөр, "Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор хамгаалалтын 40 ширхэг хаалтны 6,537.500 (зургаан сая таван зуун гучин долоон мянга таван зуу) төгрөгийг тус тус орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж хамтран ажиллалаа.	70
4.2	Сумдын Цагдаагийн хэсгийн кабоны урсгал зардал болон бусад шаардагдах зардлыг шийдвэрлэх.	Тухай бүр Орон нутгийн төсвөөс	Зардлыг шийдвэрлэсэн байна.	-	-	Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн сумдын Засаг дарга наарт цагдаагийн алба хаагч наарт дэмжлэг үзүүлэх тухай 1/376 тоот албан бичгээр үүрэг өгч,	100

						Aймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай 2021 онд байгуулсан гэрээнд тусган хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын албан үүргээ хэвийн, тасралтгүй гүйцэтгэхэд шаардагдах зардлыг төсөвтөө тусган зохих шийдвэрүүдийг гарган үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Цаг үеийн нөхцөл байдал коронавирусийн халдвараас шалтгаалан орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх санхүүжилт нь хулээгдэж байна.	
--	--	--	--	--	--	--	--

100 хувь – 1, 70 хувь - 1

85

Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр

5.1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд телекамер бүхий димапон систем нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	20.0 сая.төг	Тоног төхөөрөмж ийн хангалтын хувь	0	100	Tус аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагч болон хоригдогч, хоригдлын аюулгүй байдлыг хангах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорих байранд телекамер бүхий димапон системийг нэвтрүүлэхээр төлөвлөн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган бэлтгэл ажлыг хангаад байна. Цаг үеийн нөхцөл байдал коронавирусийн халдвараас шалтгаалан орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх санхүүжилт нь хулээгдэж байгаа тул тус заалтын хэрэгжилт удаашралттай байна.	40
-----	--	-----------------	--	---	-----	--	----

40 хувь - 1

40

Зургаа. Архив, албан хэрэг хетлөлтийн чиглэлээр

6.1	Төрийн архивт нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах	4.5 Орон нутгийн төсөв	Шаардлага тай тоног төхөөрөмж ийн дэмжлэг	50	70	Төрийн архивт хадгалагдаж байгаа баримт бичиг, хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор нийт 265 хамгаалалтын хайрцаг авч баримтыг цэгцлэх ажлыг	40
-----	--	---------------------------------	---	----	----	---	----

			үзүүлсэн байх.			зохион байгуулсан ба 572,500 төгрөгийг зарцуулаад байна.	
40 хувь - 1							40

Долоо. Улсын бүртгэлийн чиглэлээр

7.1	Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн "Гэрэгэ" систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг бүрэн арилгахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх.	4.0 Орон нутгийн төсөв	Тухайн жилд бүртгэлийн зөрчилгүй болсон иргэний тоо	1689	670	Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн "Гэрэгэ систем" нэвтрүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, "Гэрэгэ систем" ХХК-тай холбогdon үнийн судалгааг гаргаад байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл технологийн газраас мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 28-аас доош насны 8200 хүүхдийн бүртгэлийг аймгийн хэмжээнд гаргуулан авч зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Жилд 2050 хүүхдийн төрөлтийн бүртгэлийн зөрчлийг арилгахаар бодлогын баримт бичгүүдэд төлөвлөн тусгаж, иргэний улсын бүртгэгчдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэг бүртгэгч 120 зөрчлийг анхан шатны журнал бүртгэл иргэдийн гар дээр байгаа бичиг баримтад үндэслэн жагсаалтаар Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн зөрчлийг арилган ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдааар 670 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг мэдээллийн санд зөрчилгүй болголоо.	40
40 хувь - 1							40

Найм. Шүүхийн шинжилгээний чиглэлээр

8.1	Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны мэргэжлийн лабораторыг	15.0 Орон	Шаардлага тай техник,	50	70	Хими, биологийн лаборатори байгуулахаар шаардлагатай тоног	40
-----	--	--------------	--------------------------	----	----	--	----

	шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	нутгийн төсвөөс	тоног төхөөрөмж ийн хангалтын хувь			төхөөрөмжийн судалгааг лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгч Грийн Химистри ХХК-тай хамтран үнийн судалгааг гаргаж Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлэхээр бэлтгэсэн. Шүүхийн шинжилгээний албаны лабораторын барилга барих асуудлыг аймгийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил үйлчилгээнд тусгуулахаар холбогдох судалгааны материалыг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хургуулсан.	
	40 хувь - 1						40

Ес. Гадаадын иргэн, харьяатын чиглэлээр

9.1	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.6-д заасныг хэрэгжүүлж, Гадаадын харьяатын газрын орон нутаг дахь төлөөллийг ажиллах нөхцлөөр хангаж, хамтран ажиллах.		-Орон нутаг дахь төлөөллийн ажиллах нөхцөл бүрдүүлж, орон тоогоор хангасан эсэх	1	1	Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газрын Дундговь аймаг дахь төлөөлөл ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, С.Мөнхтүвшин нь 2021 оны 3 дугаар сард томилогдон ажиллаж байна. Хариуцсан хэсгийн нутаг дэвсгэрт нийт БНХАУ-ын 65 иргэн Баянжаргалан суманд Үнэн анд ХХК, Болор жонш ХХК-нуудын жоншны уурхай, Өндершил суманд Эм Ди Эф И ХХК-ны хайгуулын жонш, Говь-Угтаал суманд Чин хаш ХХК-ны тэмрийн худэр, Гурвансайхан суманд Үнэн бэрх ХХК-ны гантиг чулуу олдворлох үйл ажиллагаанууд зохих журмын дагуу хөдөлмөр эрхлэх буюу HG ангилалын виза авч, дээрх сумдуудад зөвшөөрлийн дагуу оршин суун ажиллаж байна.	100
-----	--	--	---	---	---	--	-----

100 хувь - 1						100
Арав. Хууль зүйн туслалцааны чиглэлээр						
10.1	Хууль зүйн туслалцааны төвийн салбарын өмгөөлөгчийг интернетийн орчин бүхий ажлын өрөө, тасалгаагаар ханган урсгал зардлыг хариуцаж, ажиллах нөхцлийг бүрдүүлж шаардлагатай дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.	Орон нутгийн төсвөөс -	Ажиллах нөхцөл бүрдүүлэлт	1	1	Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчинг бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас бүрэн хариуцан хэвийн ажиллуулж хэвшүүлсэн. Тус хугацаанд эрүүгийн 25 хэргийн төлбөрийн чадваргүй 31 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 132 иргэнд үзүүллээ. 100 хувь - 1
Дундаж үнэлгээ						100
						71 хувь

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Ц.МОНХБАТ

БИЕЛЭЛТИЙГ ТООЦОН ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.ЦЭНГЭЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ